

Үндэсний Статистикийн Газрын зөвшөөрснөөр
Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлав.
2005 он. № ...

Захиргааны статистикийн мэдээлэл. маягт ТВ-1

**ТЕЛЕВИЗОРТОЙ БОЛОН ИНТЕРНЭТЭД
ХОЛБОГДСОН ӨРХИЙН МЭДЭЭ**

200.. он

	нэр	код
дүүрэг		
хорооны дугаар		
Байршил		

1. Хороодын Засаг дарга өрх бүрээс авч нэгтгэн **1-р сарын 30-ны** дотор дүүргийн Статистикийн хэлтэст
2. дүүргийн Статистикийн хэлтэс нэгтгэж, **2-р сарын 25-нд** нийслэлийн Статистикийн газарт ирүүлнэ.
3. Нийслэлийн Статистикийн газар 3-р сарын 5-нд ҮСГ-т мэдээлнэ.

№		Мөрийн дугаар	Бүгд	Үүнээс: Сууцны төрлөөр				
				Монгол гэрт	Нийтийн орон сууцанд	Сууцны тусдаа байшинд	Нийтийн байранд	Бусад
	A	Б	1	2	3	4	5	6
1	Нийт өрхийн тоо	1						
2	Үүнээс: Телевизортой өрх	2						
3	Өрхөд байгаа телевизорын тоо	1 телевизортой	3					
		2 телевизортой	4					
		3 телевизортой	5					
		4 ба түүнээс дээш	6					
4	Телевизор-бүгд мөр 7 = (8+9)	7						
5	Бүгдээс:	Өнгөт	8					
6		Хар, цагаан	9					
7	Компьютертэй өрхийн тоо	10						
8	Үүнээс: Интернэтэд холбогдсон өрх	11						
9	Өрхөд байгаа компьютерийн тоо-бүгд	12						
10	Үүнээс: Зөөврийн компьютер (Laptop)	13						

Мэдээг гаргасан:

Хорооны зохион байгуулагч /ажилтан/ _____

Хянасан:

Хорооны Засаг дарга _____

200 .. оны ... -р сарын ...ны өдөр

Телевизортой болон интернэтэд холбогдсон өрхийн мэдээ (ТВ-1) гаргах товч заавар

Хаягийн хэсэг.

Энэ мэдээг нийслэлийн дүүргийн хороод өөрийн нутаг дэвсгэрийн харъяат өрх нэг бүрээр үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд нь мэдээлнэ.

Хорооны нэр, дугаарыг нөхөхдөө тухайн хорооны дугаар болон оноосон нэрийг бичнэ. Жишээ нь: 10-р хороо гэх мэтээр холбогдох баганын харалдаа мөрөнд бичнэ. Хорооны байршлын хувьд гэр хороолол -01, байшин хороолол -02, гэр, байшин хороолол холимог -03 гэсэн ангиллаар зохих шифрийг бичнэ.

Мэдээний хэсэг.

Энэхүү мэдээ нь үндсэн 10 үзүүлэлтээс бүрдэх юм. Маягтын үзүүлэлт бүр нь монгол гэрт, нийтийн орон сууцанд, сууцны тусдаа байшинд, нийтийн эзэмшлийн байранд, бусад гэсэн сууцны төрлөөр дотроо 5 баганад хуваагдана. Уг мэдээнд хэрэглэсэн сууцны төрлийн талаарх ойлголт, тодорхойлолтыг дараах байдлаар тайлбарлаж байна. Үүнд:

- Нийтийн орон сууц: Нийтийн сууцны байшин доторх сууц. Хоёр, түүнээс олон өрх амьдрахаар, тус тусдаа хаалгатай баригдсан байшин доторх нэг өрх амьдрах сууц. Тохилог орон сууцанд хоёр, түүнээс олон өрх амьдрах боломжтой, дэд бүтцийн хангамжтай (халаалтын систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг)
- Сууцны тусдаа байшин: Нэг болон түүнээс олон өрөөтэй, өрх амьдрах зориулалттай баригдсан, зарим нь дэд бүтцийн хангамжтай (халаалтын систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг)
- Нийтийн эзэмшлийн байр: Боловсролын аль ч түвшнийн оюутан, сурагчид амьдрахаар зориулсан болон ажилчид зэрэг нийтээрээ амьдардаг хүмүүсийг амьдрахад зориулсан байшинд сууж байгаа айл өрхийг хамруулна.
- Бусад: Дээр дурдсанаас бусад болон анхнаасаа хүн суух зориулалтын бус байшин, түүний нэг хэсэг буюу өрөө тасалгаанд (зориулалтаараа аж ахуйн нэгж, байгууллага байрлахад зориулагдсан гэх мэт) болон вагончик гэх зэрэгт сууж байгаа өрхийг энд хамааруулж үзнэ.

Үзүүлэлтүүдийн мөрийн дугаар тус бүрийн 1-р баганын дүн 2-оос 6-р баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.

Үүний зэрэгцээ 2-р мөрөнд тухайн баг, хорооны нийт өрхийн тооноос телевизортой өрхийн тоог сугалж нөхнө. Энэ үзүүлэлт нь тухайн өрхөд байгаа телевизорын тоо ширхэгээр 3-аас 6-р мөр хүртэл задарч нөхөгдөх бөгөөд эдгээрийн нийлбэр дүн нь 7-р мөр буюу өрхийн нийт телевизорын тоо хэмжээг харуулах мөрөнд бичигдэнэ. Түүнчлэн 7-р мөрөнд бичигдсэн нийт телевизорын тоо хэмжээ нь 8, 9-р мөрөнд задарч нөхөгдөнө. Өөрөөр хэлбэл 8,9-р мөрний нийлбэр дүн нь 7-р мөрийн дүнтэй тэнцүү байна.

10-р мөрөнд гэртээ компьютертэй айл өрхийн тоог нөхөж тавина. 11-р мөрөнд үүнээс интернэтэд холбогдсон өрхийн тоог сугалж нөхнө.

12-р мөрөнд тухайн өрхөд нийтдээ хичнээн компьютер байгааг нөхөж бичнэ. Ингэхдээ 10-р мөрийн дүн буюу компьютертэй өрхийн дүнтэй тохирч эсвэл түүнээс их байж болно.

13-р мөрөнд өрхөд байгаа нийт компьютерийн тооноос зөврийн (*Laptop, Notebook*) компьютерийн тоог сугалж нөхнө.